

ТЕЛЕВИЗҮҮДЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ДОХИОНЫ ХЭЛ, ХАДМАЛ ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛГИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6-д заасан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.17-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах Хорооноос Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан редакцын бодлогын хүрээнд төлөвлөж төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 25, нийт 46 телевизүүд дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээж байна. Харин Монгол Улсад хамрах хүрээтэй боловч спорт, кино, теле-худалдаа зэрэг төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй 13 арилжааны телевизийн хувьд дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгээгүй болно.

2026 оны эхний хагас жилийн телевизийн хөтөлбөрийн мониторингийн дүнгээр МҮОНРТ-ийн 1 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, орон нутгийн 1 телевиз, Монгол Улсад хамрах хүрээтэй 21 телевиз мөн үүрэг хүлээгээгүй боловч телевизийн редакцын бодлогын хүрээнд 17 телевиз дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийг нэвтрүүлсэн байна.

Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлгийг нийт **48** телевизээр нийт **3694** цаг нэвтрүүлсэн байна. Үүнд дээрх цагийн **67.37%-д мэдээ, мэдээлэл, 10.26%-д танин мэдэхүйн нэвтрүүлэг**, харин **20.28%-д нь хүүхдийн** нэвтрүүлэг эзлэж байна.

Хадмал тайлбартай нэвтрүүлгийг нийт **55** телевизээр **3698** цаг нэвтрүүлсэн бол нийт цагийн **20.87%-д мэдээ, мэдээлэл, 59.99%-д танин мэдэхүйн** нэвтрүүлэг, **3.19%-д хүүхдийн** нэвтрүүлэг тус тус эзэлж байна.

**Дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нийт нэвтрүүлгийн байдал
/Улаанбаатар/**

2026 оны эхний хагас жилийн байдлаар


	Нэвтрүүлгийн төрөл	Телевизийн тоо	Нийт (цаг:мин:сек)	Нийт нэвтрүүлэгт эзлэх хувь
Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	14	2608:42:47	67.37%
	Хүүхдийн нэвтрүүлэг	11	304:49:53	7.87%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	12	232:39:38	6.01%
	Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, цэнгээнт,шашин)	Кино-3 Нийгэм улс төр-27 Соёл урлаг-1 Спорт-1 Цэнгээнт-17 Шашин-1	Кино- 2:35:37 Нийгэм улс төр- 681:43:40 Соёл урлаг- 2:08:16 Спорт- 11:06:53 Цэнгээнт- 26:40:46 Шашин- 1:53:01	Кино-0.7% Нийгэм улс төр- 17.61% Соёл урлаг-0.06% Спорт-0.29% Цэнгээнт-0.69% Шашин-0.05%
	НИЙТ	37 ТВ	3470:38:48	
Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	2	836:02:25	20.87%
	Хүүхдийн нэвтрүүлэг	8	127:52:30	3.19%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	26	1631:27:36	40.72%
	Бусад нэвтрүүлэг (нийгэм, улс төр, соёл урлаг, цэнгээнт,шашин)	Кино- 2 Нийгэм улс төр-34 Соёл урлаг-7 Цэнгээнт-17 Шашин-3	Кино- 01:33:25 Нийгэм улс төр- 1064:36:22 Соёл урлаг-155:27:44 Цэнгээнт-87:34:15 Шашин-101:00:10	Кино- 0.04% Нийгэм улс төр- 26.57% Соёл урлаг-3.88% Цэнгээнт-2.19% Шашин-2.52%
	НИЙТ	44 ТВ	3590:43:48	

/Орон нутаг/

2026 оны эхний хагас жилийн байдлаар

	Нэвтрүүлгийн төрөл	Телевизийн тоо	Нийт (цаг:мин:сек)	Нийт нэвтрүүлэгт эзлэх хувь
Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Хүүхдийн нэвтрүүлэг	1	45:08:34	20.28%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	3	09:28:01	4.25%
	Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, цэнгээнт)	Кино-1 Нийгэм улс төр-4 Цэнгээнт-3 Соёл, урлаг- 1	Кино- 0:23:36 Нийгэм улс төр- 153:20:27 Цэнгээнт- 13:20:49 Соёл, урлаг- 0:56:09	Кино-0.18% Нийгэм улс төр- 68.88% Цэнгээнт-6.00% Соёл, урлаг- 0.42%
	НИЙТ	11 ТВ	222:37:36	


Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	4	20:51:24	19.27%
	Бусад нэвтрүүлэг (нийгэм, улс төр, соёл урлаг, цэнгээнт,шашин)	Нийгэм улс төр-7	Нийгэм улс төр- 87:23:04	Нийгэм ул төр-80.73%
	НИЙТ	10 ТВ	108:14:28	



ОНТВ- Дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн
төрөл, жанр /2026 оны эхний хагас жил/




ОНТВ- Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн
төрөл, жанр /2026 оны эхний хагас жил/



Тайлбар: Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн төрөл, жанраар нь харахад Улаанбаатарын телевизүүд мэдээ мэдээллийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн байдал 67% байгаа бол бичгэн тайлбартай нэвтрүүлгээс танин мэдэхүйн нэвтрүүлэг 41% хувьтай нэвтрүүлсэн байгаа нь хамгийн өндөр хувийг эзлэж байна. Харин Орон нутагт нийгэм, улс төрийн нэвтрүүлгийг 69% дохионы хэлний хэлмэрчтэй, 81% бичгэн тайлбартай нэвтрүүлсэн нь хамгийн өндөр хувийг эзлэж байна.

ДХХТ-тай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн нийт цагийн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан байдал.



1. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийг Телевиз тус бүрээр нэвтрүүлсэн тайлан

1.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн телевизүүд

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
МҮОНРТ		
1.	MNB	247:07:27
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
2.	C1	139:17:41
3.	NTV	295:02:19
4.	SBN	211:43:39
5.	UBS	366:14:40
6.	Ийгл ньюс	577:57:18
7.	Малчин	05:51:01
8.	Монгол HD	59:38:54
9.	TB5	03:26:49
10.	TB8	99:17:24
11.	TB9	98:26:15
12.	Тэнгэр ТВ	258:45:38
Арилжааны телевиз		

13.	Айст глобал	53:46:21
14.	Парламент	192:07:21
	Нийт цаг	2608:42:47
	Нийт дохионы хэлд харьцуулсан	67.37%

Дээрх нэр бүхий 14 телевиз өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө тодорхой хэмжээнд дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн ба дийлэнх нь өнгөрсөн оны мөн үед нэвтрүүлсэн телевизүүд байна. Мөн Малчин телевиз нь энэ оноос цаг агаарын мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлж эхэлсэн байна.

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг
МҮОНРТ		
1.	MNB	1:34:54
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
2.	SBN	4:17:49
3.	Малчин	8:20:26
4.	TB5	39:16:41
Арилжааны телевиз		
5.	Movie max	30:53:58
6.	National times news	8:17:02
7.	News channel	6:24:42
8.	Гандан	5:02:43
9.	Лайк	86:56:47
10.	Их засаг	32:23:58
11.	Соён гэгээрүүлэгч	2:13:05
12.	Хөгжил	6:57:33
Орон нутгийн телевиз		
13.	Сайхан Монгол	0:55:11
14.	RGB	5:09:34
15.	TB24	3:23:16
	Нийт цаг	242:07:39
	Нийт дохионы хэлд харьцуулсан УБ	6.01%
	Нийт дохионы хэлд харьцуулсан ОН	4.25%


Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад телевизийн тоо болон нийт нэвтрүүлсэн цаг багассан үзүүлэлттэй байгаа ба энэ нь тухайн нэвтрүүлгийг телевизүүд дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэхээс илүүтэй хадмал тайлбартай нэвтрүүлж байгаатай холбоотой харагдаж байна.

1.2 Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн телевизүүд

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	ETV	59:05:48
2.	Централ	78:17:41
3.	NTV	38:44:24
4.	Боловсрол суваг	37:39:22
5.	TB5	17:01:59
6.	TB8	5:59:33
Арилжааны телевиз		
7.	Channel 11	7:14:14
8.	Dream TV	39:36:10
9.	Movie Max	16:57:43
10.	Авто ТВ	3:39:09
11.	Масс ТВ	0:33:50
Орон нутгийн телевиз		
12.	TB24	45:08:34
	Нийт цаг	349:58:27
	Нийт дохионы хэлд харьцуулсан УБ	7.87%
	Нийт дохионы хэлд харьцуулсан ОН	20.28%

1.3 Бусад нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн байдал



Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн бусад төрлийн нэвтрүүлгийн хамгийн их хувийг нийгэм, улс төрийн нэвтрүүлэг эзлэж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 435 цагаас нэмэгдсэн ба спорт, цэнгээнт нэвтрүүлгүүдийн цаг мөн адил өссөн үзүүлэлттэй байна.

2. Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийг Телевиз тус бүрээр нэвтрүүлсэн тайлан

2.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	Малчин	15:01:37
Арилжааны телевиз		
2.	CNBC	821:00:18
	Нийт цаг	836:01:55
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан	20.32%

Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн хувьд дийлэнх телевизүүд дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлдэг байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан харахад арилжааны CNBC телевиз хадмал тайлбартай нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ нь хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн **19.95** хувийг эзлэж байна.

2.2 Танин мэдэхүйн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
МҮОНРТ		
1.	MNB	4:25:22
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
2.	25-р суваг	0:13:04
3.	Централ	295:51:35
4.	SBN	62:03:19
5.	Боловсрол суваг	82:03:44
6.	ETV	34:42:07
7.	Ийгл ньюс	83:06:33
8.	Малчин	10:39:27
9.	Монгол HD	62:34:42
10.	Стар	193:19:17
11.	TB5	128:29:44
12.	TB9	86:55:00
13.	Тэнгэр	25:13:48
Арилжааны телевиз		
14.	C Channel	3:54:30
15.	CNBC	7:37:16

16.	Дрийм бокс	18:27:32
17.	Mon Plus	61:27:35
18.	Movie max	100:21:01
19.	National times news	107:31:37
20.	Айст Глобал	0:49:57
21.	Бантан	7:06:03
22.	Гандан	0:14:13
23.	Монгол ТВ+1	59:51:10
24.	Мянгат малчин	1:38:06
25.	ТВ3	78:48:21
26.	Эко	114:02:33
Орон нутгийн телевиз		
27.	Эрдэнэт ТВ	13:12:58
28.	Дорнод ТВ	0:48:21
29.	Дорнод ТВ6	05:22:20
30.	Төв ТВ	1:27:45
	Нийт цаг	1652:19:00
	Нийт хадмал тайлбартай харьцуулсан УБ	40.72%
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан ОН	19.27%

Танин мэдэхүйн нэвтрүүлэг нь хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хамгийн их цаг болон хувийг эзлэж байна.

2.3 Хүүхдийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2026 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Хадмал тайлбартай нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	C1	5:21:09
2.	SBN	29:10:28
3.	Монгол HD	16:04:50
4.	Сүлд	2:40:39
Арилжааны телевиз		
5.	Дрийм	34:23:04
6.	Mon Plus	4:45:40
7.	National times news	21:28:15
8.	Монгол HD	13:58:15
	Нийт цаг	127:52:30
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан УБ	3.19%

Хүүхдийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүдийн хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

2.4 Бусад нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн байдал

Хадмал тайлбартай нэвтрүүлсэн бусад нэвтрүүлэг



Хадмал тайлбартай бусад төрлийн нэвтрүүлгийн бүх нэвтрүүлэг өнгөрсөн оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна. Хамгийн их нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувьд нийгэм, улс төрийн нэвтрүүлэг байна.

3. Дохионы хэлний хэлмэрчтэй болон Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн өөрийн бүтээлийн хувь хэмжээ

Телевизүүдийн хувьд тодорхой хувь хэмжээнд мэдээ мэдээллийн нэвтрүүлэг, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг болон бусад олон төрлийн нэвтрүүлгийн нэвтрүүлж үзэгч олонд хүргэж байна. Харин нэвтрүүлж байгаа нэвтрүүлгээс хэдэн хувь нь өөрсдийн студи болон өөрсдийн редакцын бодлогын хүрээнд бүтээсэн бүтээл байгааг доорх графикаар харуулж байна. Энэхүү үзүүлэлт нь 2026 оны жилийн эцсийн дүнгээр өөрчлөгдөх боломжтой юм.


Мэдээ, мэдээллийн хөтөлбөр /ДХН/



Танин мэдэхүйн нэвтрүүлэг /ДХН/




Хүүхдийн нэвтрүүлэг /ДХН/



Нийгэм, улс төрийн нэвтрүүлэг /ДХН/




Соёл, урлаг нэвтрүүлэг /ДХН/




Улаанбаатар хотын 37 телевизээр 2026 оны эхний хагас жилд телевизүүдийн дохионы хэлний хэлмэрчтэй нийт 3872 цагийн нэвтрүүлгийг нэвтрүүлсэн байна. Үүнээс 3471 цагийн буюу 89% хувийг өөрсдийн редакцын бодлогийн хүрээнд бүтээсэн өөрийн бүтээл байна. Өөрийн бүтээлээс хамгийн их хувийг буюу 75.21% нь мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг байгаа бол нийгэм, улс төрийн нэвтрүүлэг 13.46%, хүүхдийн нэвтрүүлэг 6.18%, танин мэдэхүйн нэвтрүүлэг 4.92%-г эздэж байна.


Дээрх хувь хэмжээнээс харахад телевизүүд дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлгийг дийлэнхдээ өөрсдийн нөөцөд тулгуурлан бүтээж байна.

Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг /БТН/



Танин мэдэхүйн нэвтрүүлэг /БТН/





Улаанбаатар хотын 44 телевизээр 2026 оны эхний хагас жилд хадмал тайлбартай нийт 4006 цагийн нэвтрүүлгийг нэвтрүүлсэн байна. Үүнээс 1279 цаг буюу 31.93% хувийг өөрсдийн редакцын бодлогийн хүрээнд бүтээсэн өөрийн бүтээл байна. Өөрийн бүтээлээс хамгийн их хувийг буюу 61.58% нь танин мэдэхүйн нэвтрүүлэг байгаа бол нийгэм, улс төрийн нэвтрүүлэг 18.86%, хүүхдийн нэвтрүүлэг 5.59%, мэдээ мэдээллийн нэвтрүүлэг 1.17%-г эзлэж байна.

4. Телевизүүдийн 2026 оны эхний хагас жилд төлөвлөлтийн дагуу нэвтрүүлсэн байдал

Тус хороо нь 2025 оноос Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 25, нийт 46 телевизүүдээс дохионы хэлний хэлмэрчтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтийг хагас жил тутам шинэчлэн гаргуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа ба үүний дагуу 2025 оны сүүлийн хагас жилийн төлөвлөлтийг өргөн нэвтрүүлгийн 15, орон нутгийн 3, Арилжааны 24 телевиз ирүүлснийг хорооны цахим хуудсаар мэдээлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, төлөвлөлтийг үе шаттай нэмэгдүүлээгүй үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

📺 Өргөн нэвтрүүлгийн телевиз

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн нэр	Нийт хугацаа (секундээр)		Хөтөлбөрт эзлэх хувь-2026 эхний хагас жил				Нийт хувь	Нийт Хувь
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохионы хэл	Аль аль нь байгаа		
1	Ийгл	Ийглийн мэдээ		1,954,800	5,419,560		16.8%		47.9%	21%
		Дэлхийн мэдээ		975,000			8.8%			
		Иргэний мэдээ		1,560,000			14.0%			
		Юу болов		312,000			2.8%			
		Deutsvhe welle Даяарчлал 3000 нэвтрүүлэг	205,920			1.8%				
		Deutsvhe welle Германд үйлдвэрлэв	205,920			1.8%				

		Deutshe welle Euromaxx	205,920			1.8%				
2	Монгол HD	Оргил цаг		388,800	1,191,840		3.0%		9.1%	6%
		Өнөө өглөө		240,000			1.8%			
		Хар хайрцаг	248,040			1.9%				
		Баримтат кино	315,000			2.4%				
3	ETV	Хүүхэд нэгдүгээрт		115,200	147,600		1.0%		8.6%	3%
		Хотын бүсгүй хөдөө нутагт		32400			0%			
4	NTV	Мэдээ		1,296,000	1,380,000		8.99%		9.57%	8.3%
		Хүүхдээ нааш ир		84,000			0.58%			
5	Стар	Нүүдэлчдийн өв	252,000		1,048,500	2.40%			10%	6.8%
		Миний уншсан ном	378,000			3.61%				
		Хамтдаа	418,500			3.99%				
6	TM	Таны мэдээ		234,000	702,000		2.10%		6.30%	0.0%
		Дуусаагүй түүх		140,400			1.26%			
		Глобал		187,200			1.68%			
		Германд үйлдвэрлэв		140,400			1.26%			
7	TB9	Энэ өдөр		1,053,000			8.93%		8.93%	3%
8	Малчин	Шинэ сарын шинж нэвтрүүлэг	59,400		253,800		0.53%		2.28%	2.67%
		Сарын хуучийн тэнгэр нэвтрүүлэг	59,400				0.53%			
		Малчин айлд		135,000			1.21%			
9	Централ	Ройтерс	972,000		1,440,000	8.2%			12.2%	9%
		Гарчиг	252,000			2.1%				
		Never too small	108,000			0.9%				
		Engineering tomorrow	108,000			0.9%				
10	C1	C1 Мэдээллийн хөтөлбөр		1,200,000	1,401,600		10.18%		11.88%	5.1%
		Inside out Сэтгэл зүй		201,600			1.71%			
11	TB5	Цаг хөтөлбөр		115,200	496,800		0.98%		6.65%	1.8%
		Цаг мэдээний хөтөлбөр		57,600			0.49%			
		Өвөг дээдсийн өв соёл		288,000			2.44%			
		Япон орныг тольдохуй	28800				0.24%			
		Үзэсгэлэнт Итали орноор	79200				0.67%			
		Шидэт харандаа		216,000			1.83%			
12	TB8	Толь		850,500	1,966,500		7.21%		16.67%	3.2%

		Аялалын влог /аялалын влог/		468,000			3.97%			
		Хүүхдийн нэвтэрхий толь		648,000			5.49%			
13	Боловсрол	National geographic	540000		1,862,400	5.2%			19.0%	3%
		Аугаа уран зураг	28800			2%				
		Шинжлэх ухаан	165000			1.6%				
		Монголчуудын 20-р зуун	66000			0.6%				
		Монголчууд нийгэмд давшин орсон нь	72600			0.7%				
		Музей	990000			9.4%				
14	UBS	City News		1,638,000		14.7%			14.7%	12%
15	25-р суваг	Сонин хачин	450000			4.3%			4.3%	0%
16	Сүлд	Цаг үе		468,000	777,600	4.0%			6.6%	0%
		Гийнгоо	93600							
		Сод урлан	216000							
17	Тэнгэр	07:10 мэдээ		1,056,000	1,126,200		8.95%		9.55%	8.7%
		Билиг	70200			0.6%				
18	SBN	SBN news		604,800	1,719,000		5.77%		16.4%	10.4%
		SBN news		171,000			1.63%			
		Нахиа+3	244800			0.02				
		Нахиа+6,+12	244800			0.02				
		Түүхэн хэлхээ	172800			0.02				
		Түүхийн хуудаснаа	108000			0.01				
		Өв соёл өнөө цагт	172800			0.02				

 Арилжааны телевиз

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн нэр	Нийт хугацаа (секундээр)		Хөтөлбөрт эзлэх хувь-2026				Нийт хувь	2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохионы хэл	Аль аль нь байгаа		Хувь
1	Dreambox	Шидэт плазм	-	25,920	38,520	-	0.3%	-	0.4%	3.41%
		Дэггүй хайгуулч	12,600	-		0.1%	-	-		
2	Блумберг ТВ Монголиа	Ярилцах цаг	178,560	-	446,400	1.7%	-	-	4%	4.78%
		Дэвид Рубенштэйний шоу	133,920	-		1.3%	-	-		
		Cars&Coffee	133,920	-		1.3%	-	-		
3	Moviemax	Өвөг дээдсийн өв соёл		612,000	1,101,600	-	5.2%	-	9%	4.52%
		Шидэт харандаа	-	288,000		-	2%	-		
		Япон орноор	201,600			2%	-	-		
4			28,800	-	28,800	0.24%	-	-	0.24%	0.19%

	Мянгат малчин	Мэдлэгт дусал нэмэр					-	-		
5	Масс Тв	Баялаг бүтээгч	-	26,400	136,800	-	0.22%	-	1%	1.18%
		Боргоцойн эрэлд	-	74,400		-	0.63%	-		
		Хүүхэд нэгдүгээрт	-	36,000		-	0.31%	-		
6	Бидний цөөхөн Монголчууд	Аян замын тэмдэглэл		36,000	75,600	-	-	0.3%	1%	-
		Эгэл баатар		18,000		-	-	0.7%		
		Миний нутаг		21,600		-	-	0.2%		
7	Хөгжил ТВ	Бүсгүйчүүд	-	32,400	32,400	-	0.25%	-	0.25%	0.23%
8	Гандан	Хүүхдийн ертөнц	99,000	-	175,800	1.01%	-	-	1.79%	4.02%
		Төгс баясгалант их хөлгөний орон	76,800	-		0.78%	-	-		
9	Чаннел 11	Аялагч Б.Мөнхцэлмэг /аялалын влог/	-	468,000	468,000	4.5%	-	-	4.5%	0.62%
10	Талын Монгол	Уламжлал-Өв соёл	64,800	-	86,400	0.6%	-	-	1%	-
		Уламжлал-Өв соёл	-	21,600		-	0.2%	-		
11	Монгол ТВ+1	Баримтат кино	226,800	-	226,800	3.46%	-	-	3%	4.30%
12	ТВ3	Дэлхийн хотууд	43,200	-	230,400	0.41%	-	-	2%	2.71%
		Сонголт	72000	-		0.7%	-	-		
		Бренд	43200	-		0.4%	-	-		
		Эрүүл тархи	72000	-		0.7%	-	-		
13	NTN	National times news	-	561,600	1,745,640	-	5.0%	-	16%	4.88%
		Альпийн нурууд	99000	-		0.9%	-	-		
		Африкийн гайхамшигт хүрээлэнгүүд	99000	-		0.9%	-	-		
		Дөлгөөн аварга уулын диваажин	33000	-		0.3%	-	-		
		Европын сэрүүн хавар	66000	-		0.6%	-	-		
		Мадагскар-улаан арлын ногоон эрдэнэ	33000	-		0.3%	-	-		
		Махчин халимны баг	33000	-		0.3%	-	-		
		Хавар амьдрал эргэн ирлээ	33000	-		0.3%	-	-		
		Хаврын үлгэрүүд	33000	-		0.3%	-	-		
		Цагаан чоно-хойд туйлын сүнс	33000	-		0.3%	-	-		
		"Ган хүлэг" цуврал 1905 Stanley steamer	13860	-		0.1%	-	-		
		"Ган хүлэг" цуврал 1906 National Model E-5XW	12540	-		0.1%	-	-		

	" Ган хүлэг" цуврал 1908 Ford Model T	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1914 RENAULT MODEL	13860	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1924 Maxwell Chryslers	13200	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1925 Rolls Royce	13860	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1929 mclaughlin buick	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1932 duesenberg model	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1934 chrysler walter	14520	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1938 Pierce Arrow Limoisine	13200	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1939 rolls royce phanton	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1948 alfa.romeo	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1950 Studebaker commander	13860	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1950 Citrben DS21	11220	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1957 BMW 300	13860	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1965 honda s600	15180	-	0.1%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1965 Lincoln continental	15180	-	0.14%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1965 posche 356 coupe	15180	-	0.14%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1967 corvette stingray	15180	-	0.14%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1970 ford mustang	15180	-	0.14%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1990 Honda	13860	-	0.12%	-	-
	" Ган хүлэг" цуврал Like ferrari	12540	-	0.11%	-	-
	" Ган хүлэг" цуврал 1905 Stanley steamer	13860	-	0.12%	-	-

		Дэлхий ертөнц 5	198000	-		1.78%	-	-		
		Дэлхий ертөнц 6	198000	-		1.78%	-	-		
14	Их засаг	Хичээлийн хуваарь	96000		96000	-	-	0.92%	1%	2.60%
15	Өлзий	Буян ном оршихуй	198000	-	198000	1.68%	-	-	2%	1.09%
16	Лайк	Эрүүл мал эрдэнэ	-	43200	86400	-	0.39%	-	1%	2.83%
		Эмч зөвлөж байна	-	43200		-	0.39%	-		
17	Лайв	"Шууд" мэдээллийн хөтөлбөр	-	172800	172800	-	1.65%	-	2%	0.37%
18	Эко	Эко зөвлөгөө	12000	-	12000	0.10%	-	-	0.10%	3.48%
19	NTV Sport	Дакар ралли 2026	277200	-	367200	2.64%	-	-	4%	-
		Алула Тур	90000	-		0.86%	-	-		
20	Аист Глобал	Монголчуудад буриадаас-1	-	15120	361200	-	0.13%	-	3%	5.05%
		Монголчуудад буриадаас-2	-	15120		-	0.13%	-		
		Монголчуудад буриадаас-3	-	15120		-	0.13%	-		
		Монголчуудад буриадаас-4	-	20160		-	0.17%	-		
		Монголчуудад буриадаас-5	-	20160		-	0.17%	-		
		Монголчуудад буриадаас-6	-	30240		-	0.26%	-		
		Монголчуудад буриадаас-7	-	35280		-	0.30%	-		
		Монголчуудад буриадаас-8	-	30240		-	0.26%	-		
		Монголчуудад буриадаас-9	-	35280		-	0.30%	-		
		Монголчуудад буриадаас-10	-	35280		-	0.30%	-		
		Монголчуудад буриадаас-11	-	50400		-	0.43%	-		
		Монголчуудад буриадаас-12	-	35280		-	0.30%	-		
		АТ ТОП-1	-	10080		-	0.09%	-		
		АТ ТОП-2	-	13440		-	0.11%	-		
21	Соён гэгээрүүлэгч	Бага хуралдай эрдмийн чуулган	594000	-	594000	3.78%	-	-	4%	0.05%
22	Парламент	"Төв цэг" 7 хоногийн тойм	-	201600	403200	-	1.92%	-	4%	7.68%
		"Төв цэг" Дэлхийн тойм	-	201600		-	1.92%	-		
23	TB2	Цаг агаарын мэдээ	756000	-	756000	9.62%	-	-	10%	-
24	MNC	MNC мэдээллийн хөтөлбөр	334800	-	502200	3%	-	-	5%	-
		Зочны цаг	167400	-		2%	-	-		
25		CNBC мэдээ	2678400	-	10242000	24%	-	-	92%	43.30%

CNBC Mongolia	CNBC Азийн хөтөлбөр	1872000	-	17%	-	-
	CNBC Европын хөтөлбөр	1404000	-	13%	-	-
	CNBC Хойд Америкийн хөтөлбөр	2340000	-	21%	-	-
	CNBC ярилцлага	216000	-	2%	-	-
	Азийн манлайлагчид	259200	-	2%	-	-
	Зоригтнууд	108000	-	1%	-	-
	Хөрөнгө оруулалтын цаг	140400	-	1%	-	-
	CNBC тусгай томилот	54000	-	0.5%	-	-
	Тогтвортой хөгжлийн ирээдүй	75600	-	1%	-	-
	Тэгш байдал ба боломж	54000	-	0.5%	-	-
	Маркетинг, медиа, мөнгө	140400	-	1%	-	-
	Шинийг бүтээгчид	43200	-	0.4%	-	-
	Нэгдүгээр зэрэглэл	54000	-	0.5%	-	-
	Талархалын урлаг	54000	-	0.5%	-	-
	CNBC international шууд дамжуулалт (амралтын хөтөлбөр)	748800	-	7%	-	-

Орон нутгийн телевиз

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн нэр	Нийт хугацаа (секундээр)			Хөтөлбөрт эзлэх хувь-2025 сүүлийн хагас жил			Нийт хувь	2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохионы хэл	Аль аль нь байгаа		
1	ТВ 24	24 цаг мэдээллийн хөтөлбөр	-	1,036,800	1713600	-	7.5%		12.5%	27.3%
		"Өв соёлын цадиг" нэвтрүүлэг	345600			-	-	3%		
		ТВ24 Өдрийн мэдээ	-	151200		-	1%			
		"Охидын өрөө" нэвтрүүлэг	180000			-	-	1%		

Телевизүүдийн төлөвлөлтийг хувьчлан харахад нийт 44 телевизээс төлөвлөлт ирүүлсэн ба төлөвлөлт нь 0-5% хооронд төлөвлөсөн 24 телевиз, 5-10% хооронд төлөвлөсөн 10 телевиз, 10-20% хооронд төлөвлөсөн 7 телевиз, 20% дээш төлөвлөсөн 3 телевиз байна. Үүнээс

гүйцэтгэлийг харахад 0-5% хооронд 31 телевиз, 5-10% хооронд 8 телевиз, 10-20% хооронд 2 телевиз, 20% дээш 3 телевиз нэвтрүүлсэн байна. Мөн нийт 44 телевизээс 13 телевиз төлөвлөлтөндөө хүрч ажилласан байна.

Дүгнэлт: Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн цаг өнгөрсөн оны мөн үеэс 410 цагаар нэмэгдсэн ч телевизийн тооны хувьд 3-аар буурсан, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувьд 4 телевизээр нэмэгдэхийн зэрэгцээ нэвтрүүлгийн цаг 2395-аар өссөн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлгийн нэвтрүүлсэн нийт хугацаа нэмэгдсэн ч нэвтрүүлсэн телевизийн тоо буурсан нь цөөн тооны телевиз илүү урт хугацаагаар нэвтрүүлэг хүргэж байгааг илэрхийлж байна. Мөн нийт нэвтрүүлж буй нэвтрүүлгийг төрөл жанраар авч үзэхэд дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлгийн хүртээмж нь түлхүү мэдээ мэдээлэл болон нийгэм, улс төрийн чиглэлд төвлөрч байна. Харин хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувьд нэвтрүүлсэн телевизийн тоо, нэвтрүүлсэн цаг аль аль нь нэмэгдсэн ба нэвтрүүлгийн төрлөөр авч үзвэл танин мэдэхүйн нэвтрүүлэгт төвлөрсөн хэвээр байна.

Цаашид дохионы хэлний хэлмэрчтэй болон хадмал тайлбартай нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэхдээ нэвтрүүлгийн цагаас илүүтэйгээр төрөл жанрыг олшруулах нь хүртээмжийг илүү нэмэгдүүлэх ач холбогдолтой харагдаж байна.

Телевизүүдийн 2026 оны эхний хагас жилийн дохионы хэлний хэлмэрчтэй болон хадмал тайлбартай нэвтрүүлгийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлээс харахад хүртээмжийг үе шаттай нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч, хувь хэмжээг өмнөх хугацааны гүйцэтгэлээс нэмэгдүүлж, цаг хугацаанд нь ирүүлэн түүний биелэлтийг хангаж ажиллахаар идэвхи чармайлт гарган ажиллаж байна. Гэвч зарим нэг зүйл дээр анхаарал хандуулах, зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал: Дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийн төрөл жанр, нийт эфирт эзлэх цагийн төлөвлөлт нь телевиз тус бүрийн хувьд харилцан адилгүй, зарим телевизүүдийн хувьд хэт зөрүүтэй байгаа нь тухайн телевизийн редакцын бодлого, ажиллах хүч, техник, санхүүгийн нөөц боломжоос шалтгаалж байх боломжтой юм. Иймд цаашид зөвхөн нийт эфирийн цагт эзлэх дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хугацаа, тоог нэмэгдүүлэхээс гадна телевиз тус бүрээр жигд нэмэгдүүлэн төлөвлүүлэх, мэдээ, мэдээлэл, нийгэм, улс төр, танин мэдэхүйн нэвтрүүлгээс гадна хүүхэд, боловсрол, спорт зэрэг нийгмийн ач холбогдолтой бусад төрлийн нэвтрүүлгүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-д дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийн төрлийг нэмэгдүүлж, өөрчлөлт оруулахаар санал тусган хэлэлцүүлэгт гаргаад байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО